

**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2015 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 60 тоот тогтоолын  
хавсралтууд**

**Хорооны 2015 оны 60 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт:**

Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2013 оны 49 тоот тогтоолын  
Нэгдүгээр хавсралт

**Интернетийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тусгай  
нөхцөл шаардлага**

**(Хорооны 2015 оны 60 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар  
нэмэлт, өөрчлөлт оруулсан)**

**1. Ерөнхий зүйл**

- 1.1. Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид Зохицуулах хороо гэх) өөрийн вэб сайтдаа интернетийн үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн санг (цаашид нэгдсэн сан гэх) бий болгох бөгөөд уг санд интернетийн үйлчилгээ эрхлэгчид<sup>1</sup> холбогдоно.
- 1.2. Нэгдсэн санд бүрдүүлэх шаардлагатай мэдээллүүдийг Зохицуулах хорооноос тогтооно. Үүнд:
  - Бүсчлэн хуваасан АйПи(IP) хаягууд, тэдгээрт харгалзах хурд болон төхөөрөмжүүд
  - Хэрэглэгчийн тоо
  - Хэрэглэгчидтэй байгуулж байгаа гэрээний загвар
  - Монголын интернет солилцооны төвд (MIX) холбогдсон эсэх
  - Эталон цагт холбогдсон байдал
  - АПНИК (APNIC)-аас авсан АйПи(IP) хаягийн блок болон ЭйЭс(AS) дугаар
  - Кэйш серверийн ашиглалтын тухай
  - Бусад
- 1.3. Интернетийн үйлчилгээ эрхлэгч нь нэгдсэн санд мэдээллээ өөрчлөгдөх тухай бүрд шинэчилнэ.
- 1.4. Интернетийн урсгалыг Мэдээлэл холбооны улс хоорондын сүлжээ, дэд бүтэц байгуулах, түүнийг ашиглах А ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс<sup>2</sup> түрээслэнэ.
- 1.5. Тухайн үйлчилгээ хүргэхээр төлөвлөсөн байр, байшинд хэрэглэгчийн сонголтыг нээлттэй байлгаж, зөвхөн өөрийн үйлчилгээг ашиглуулахын тулд бусад үйлчилгээ эрхлэгчдэд хаалт учруулахыг хориглоно.
- 1.6. Үүрэн холбооны үйлчлэгч нь үүрэн холбооны сүлжээний хүрээнд интернетийн үйлчилгээ үзүүлэхэд тусдаа интернетийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохгүй ба үүрэн холбооны болон 3G тусгай зөвшөөрөлд нь багтана.

---

<sup>1</sup> Интернетийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийг “Интернетийн үйлчилгээ эрхлэгч” гэнэ.

<sup>2</sup> Мэдээлэл холбооны улс хоорондын сүлжээ байгуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийг “Бөөний үйлчилгээ эрхлэгч”

## **2. Харилцан холболт, сүлжээнд холбогдох**

2.1. Монгол улсын дотоодын интернет урсгалыг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, сүлжээний болон үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор интернетийн үйлчилгээ эрхлэгч нь хоёроос доошгүй “Интернетийн харилцан холболт”-ын төвд холбогдоно (Энэхүү шаардлага нь зөвхөн Улаанбаатар хотод үйлчилгээ эрхлэгчдэд хамаарна).

*(Хорооны 2015 оны 60 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар өөрчлөн найруулсан)*

2.2. Хэрэв төрийн байгууллагад интернетийн үйлчилгээ үзүүлдэг бол төрөөс зохион байгуулсан “Интернетийн харилцан холболт”-ын төвд холбогдоно (Энэхүү шаардлага нь зөвхөн Улаанбаатар хотод үйлчилгээ эрхлэгчдэд хамаарна).

*(Хорооны 2015 оны 60 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар нэмэлтээр оруулсан)*

2.3. Тус хорооноос зохион байгуулсан сүлжээний цагийн нэгдсэн серверээр дамжуулан Монгол улсын эталон цагтай холбогдоно.

2.4. Бөөний үйлчилгээ эрхлэгчтэй холбогдохдоо үндсэн замчлагч төхөөрөмж (рүотер) нь 1Гбит/сек-с доошгүй үзүүлэлтээр харилцан холболт хийх боломжтой байна. (Энэхүү шаардлага нь зөвхөн Улаанбаатар хотод үйлчилгээ эрхлэгчдэд хамаарна)

## **3. Үйлчилгээний чанар**

3.1. Интернетийн урсгалын хурдыг хянах боломжоор хэрэглэгчдээ хангах үүднээс хэрэглэгчийн гэрээ, вэб хуудас, хэрэглэгчийн гарын авлага, хэрэглэгчийн төхөөрөмж зэрэгт [www.speedtest.mn](http://www.speedtest.mn) веб хуудсыг сурталчилан таниулж, хэрэглүүлнэ.

3.2. Хэрэглэгчийг дотоодын интернетийн урсгалд (Монгол улсад байрлаж байгаа вэб, имэйл, файл хостинг гэх мэт хэрэглээ) хурдны хязгаарлалтгүй холбоно. Харин гадаад урсгалын хурдын хувьд хэрэглэгчтэй байгуулсан гэрээнд заасан хурдыг хангана.

## **4. Техникийн нөхцөл шаардлага**

4.1. Интернетийн урсгалын багтаамжийн хэмжээ нь 10-аас доошгүй хувийн нөөцтэй байхаар тооцож авна. Хэрэв сард 10 буюу түүнээс дээш хоногт урсгалын нөөц хүрэхгүй болсон тохиолдолд урсгалын хэмжээг хангалттай хэмжээнд хүртэл нэмэгдүүлнэ.

4.2. Айл өрхөд интернетийн үйлчилгээг үзүүлэхдээ үндсэн сүлжээнд “Сүлжээний хамгаалалтын төхөөрөмж” ашиглана.

4.3. АйПи хаягийн 4 болон 6 –р хувилбарыг (IPv4,IPv6) хослуулан ашиглах (Dual-stack) техникийн боломжийг бүрдүүлсэн байна.

- 4.4. Гадаад гарцын сүлжээнд гэмтэл саатал гарах үед авах арга хэмжээг тодорхойлсон, тэдгээрийг хэрэгжүүлэх техникийн боломжийг бүрдүүлсэн байна.
- 4.5. Үндсэн серверүүд (DNS, PPPoE биллинг)-ийг кибер халдлагаас хамгаалах бөгөөд хэрхэн хамгаалагдаж байгаа талаар үзлэг шалгалтыг хуваарийн дагуу тогтмол хийж, протокол хөтлөдөг байна.
- 4.6. Сүлжээний зангилаа цэгүүдэд 3 цагаас багагүй хугацаанд барих зай тэжээл найдвартай хангагдсан байна.
- 4.7. Интернетийн үйлчилгээнд гадаад АйПи(IP) хаягийг хамгийн ихдээ 20 хэрэглэгчийн дунд нэг байхаар зохион байгуулна.
- 4.8. Хэрэглэгчийн интернет үйлчилгээнд хаягийн хувиргалт (NAT) ашиглах тохиолдолд хэрэглэгчийн нэг удаагийн холболтондох бүх хандалт нэг л гадаад АйПи(IP) хаягаар байна.
- 4.9. Интернетийн портыг (TCP,UDP) Интернетийн дугаар олгох байгууллага (IANA) -с албан ёсоор тогтоон хуваарилсан жагсаалтыг баримтлан нээлттэй байлгана. Харин бусад албан бус портын дугаарыг нээлттэй байлгах тохиолдолд үйлчилгээгээр тусад нь ангилан хэрэглэгчдэдээ санал болгоно.
- 4.10. Интернетийн үйлчилгээ эрхлэгчид нь коллектор сервертэй байх ба уг серверээс шаардлагатай мэдээллүүдийг авах боломжоор Зохицуулах хороог хангана.

## **5. Хэрэглэгчийн үйлчилгээ**

- 5.1. ХХЗХ-оос зарласан зөрчилтэй интернет домэйн нэр, веб сайтыг өөрийн серверээр дамжуулан интернетэд холбохгүй байна.
- 5.2. Төрийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудад интернетийн үйлчилгээг үзүүлэх тохиолдолд насанд хүрэгчдэд зориулсан вэб хуудсыг хаана.
- 5.3. Айл өрхийн интернетэд насанд хүрэгчдэд зориулсан контент (+18) руу хандах хандалтыг хязгаарласан (систем эсвэл програм хангамжийн) үйлчилгээтэй байна. Энэ үйлчилгээг хэрэглэгчийн гэрээ болон байгууллагын веб сайтаар дамжуулан иргэдэд мэдээлнэ.

**(Хорооны 2015 оны 60 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар өөрчлөлт оруулсан)**

## Хорооны 2015 оны 60 тоот тогтоолын 2 дугаар хавсралт:

Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2011 оны 08 тоот тогтоолын  
хавсралт

### ТООН КОНТЕНТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

(2012 оны 18 дугаар тогтоол, 2014 оны 40 дүгээр тогтоол, 2015 оны 60 тоот тогтоолын  
2 дугаар хавсралтаар тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж баталсан)

#### 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Харилцаа холбооны тухай хуулийн 8.1, 9.1.2, 12.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16.3-д заасныг тус тус үндэслэн харилцаа холбооны сүлжээгээр контентын болон веб сайтын үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү ерөнхий нөхцөл шаардлагыг баримтлана.

*/2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

1.2. Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “Зохицуулах хороо” гэх) болон, контентын агрегатор, контент нийлүүлэгч, веб сайтын үйлчилгээ эрхлэгч, контентын үйлчилгээтэй холбогдсон харилцаанд энэхүү зохицуулалтыг дагаж мөрдөнө.

#### 2. ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. “Контент” гэж харилцаа холбооны сүлжээгээр дамжиж байгаа тэмдэгт, дохио, текст, зураг, дуу, авиа, дүрс, бичлэг болон бүх төрлийн мэдээ мэдээллийг тоон хэлбэрт хувиргасан бүтээгдэхүүн; Энэхүү контентид дараахь зүйлс хамаарахгүй. Үүнд:

- Цахим шуудан, балк болон спам захидал;
- Хувь хүмүүсийн хоорондын харилцаа (Жишээ нь: телефон яриа, факс, Айпи телефон яриа гэх мэт);

2.2. “Контент нийлүүлэгч” гэж олон төрлийн эх үүсвэрээс контентийг эргэн ашиглах эсвэл дахин худалдах зорилгоор цуглуулан, үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр болон интернетийн сүлжээгээр дамжуулахын тулд өөрийн тоног төхөөрөмж, программ хангамжийг ашиглан хувиргах, тохируулах, борлуулах зорилготой контент нийлүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд. */2015 оны хорооны хуралдааны 60 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар өөрчлөлт оруулсан/*

2.3. “Контент бүтээгч” гэж контентийн зохиогчийн эрхийг эзэмшигч, эсхүл контентыг хөгжүүлэн контент нийлүүлэх үйлчилгээ эрхлэгчдэд нийлүүлдэг хувь хүн, хуулийн этгээд; Үүнд дуучид, хөгжимчид, зохиолчид гэх мэт мэдээллээр хангагчид, болон програм хангамж ашиглан контентыг бий болгогчид. */2015 оны хорооны хуралдааны 60 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар өөрчлөлт оруулсан/*

- 2.4. “Веб сайтын үйлчилгээ эрхлэгч” гэж харилцаа холбооны сүлжээний үйлчилгээг ашиглан олон нийтэд мэдээ, мэдээлэл болон бусад бүх төрлийн контентыг хүргэдэг иргэн болон хуулийн этгээд. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

### 3. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

- 3.1. Контентын үйлчилгээний тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Харилцаа холбооны тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн Зохицуулах хорооноос баталсан нөхцөл шаардлага, холбогдох журмын дагуу олгоно.
- 3.2. Зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг ил тод нээлттэй байлгана.
- 3.3. Контентын үйлчилгээний тусгай зөвшөөрлийг дараах төрлөөр олгоно:
- 3.3.1. Контент **нийлүүлэгч**;
- ✓ Мобайл (үүрэн холбооны хэрэглэгчийн гар утасны функц, үйлдлийн системд тохируулан бүтээсэн тоон контентын үйл ажиллагаа явуулах боломжтой этгээд байна)
- /2015 оны хорооны хуралдааны 60 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар өөрчлөлт оруулсан/*
- 3.4. Харилцаа холбооны тухай хуулийн 12.3 дахь заалтыг үндэслэн Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй мэдээ мэдээллийн веб сайтын үйлчилгээ эрхлэгч нь Зохицуулах хороонд бүртгүүлнэ<sup>3</sup>.
- 3.5. Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагын танилцуулга, нийгмийн сүлжээ, хувийн блог, өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хүргэдэг веб сайтууд нь уг нөхцөл шаардлагад хамаарахгүй. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан/*
- 3.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүрэг, хариуцлага, үндсэн үйл ажиллагаатай холбоотой харилцаагаа бусдад шилжүүлэхийг хориглоно.

### 4. КОНТЕНТИЙН АГУУЛГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Контентийг бүтээж, түгээх, сурталчилахад Монгол Улсын холбогдох хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (түүний дотроос 3.3.3.Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, 3.3.4.Нийгмийн тогтвортой байдал)-ыг мөрдлөг болгох ба дор дурдсан болон бусад холбогдох хууль зөрчсөн контент бүтээх түгээх нь хуулиар хориотой

---

<sup>3</sup> Хэрэв веб сайтын үйлчилгээ эрхлэгч нь бүртгэлийн гэрчилгээ авах хүсэлтэй бол “бүртгэлийн гэрчилгээ хүссэн өргөдөл”-г бөглөн бүртгэлийн хураамж 80,000₮ ХХЗХ-ны Голомт банкны 1102626829 тоот дансанд, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 30.4-д заасан 20,000₮ төгрөгийг ХХЗХ-ны Голомт банкны 1165009467 тоот дансанд тушаана.

- 4.1. Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 8.1, 8.1.2, 8.1.3, 9.3, Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлийг илэрхийлсэн. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*
- 4.2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 8.1.3 дугаар зүйлийг илэрхийлсэн.
- 4.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-д заасан зүйлсийг сурталчилсан, илэрхийлсэн.
- 4.4. Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлийн дагуу үндэсний эв нэгдлийг бусниулах чиглэлээр сурталчилгаа явуулсан.
- 4.5. Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлийн дагуу хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан, гүтгэлгийг олон нийтэд тараасан, эсхүл доромжилсон. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*
- 4.6. Эрүүгийн хуулийн 178<sup>3</sup> дугаар зүйлийн дагуу терроризмийг сурталчилсан.
- 4.7. Эрүүгийн хуулийн 179 дугаар зүйлд заасан нийтийн эмх замбараагүй байдалд өдөөн турхирсан.
- 4.8. Эрүүгийн хуулийн 144 дугаар зүйлийн дагуу шашны харгис үзэл номлолыг сурталчилсан.
- 4.9. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1.2-д заасан зүйлсийг илэрхийлсэн.
- 4.10. Зар сурталчилгааны тухай хуулийн 6-р зүйлийн 6.5.5, 6.5.7, 6.5.8 болон 7-р зүйл, 13.4, 13.6, 13.8, 14-р зүйл, 16-р зүйл, 17.2-д заасан зар сурталчилгаа агуулсан.
- 4.11. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 12.1, 12.2, 20.1, 21.1, 22.1, 25.1 –д заасныг зөрчиж, зохиогч эсхүл эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр бүтээлийг нь ашигласан.
- 4.12. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-д заасан согтууруулах ундаа сурталчилсан .
- 4.13. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1.6-ийн дагуу хүүхдийн хүмүүжил, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлсэн.
- 4.14. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5-д заасан зүйлсийг илэрхийлсэн.
- 4.15. Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйл 7.2.3-ийн дагуу эротик төрлийн контентийг агуулсан.
- 4.16. Их хурлын сонгуулийн тухай хуулийн 37-р зүйлийн 37.15.4-д заасан үйл ажиллагаа явуулсан. */2012 оны 3-р сарын 23-ны өдрийн хорооны хуралдааны тогтоолоор нэмсэн/*
- 4.17. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3-р зүйлийн 3.6.1.2: нийгмийн сэтгэл зүй, тогтвортой байдал, хувь хүний ухамсар, ёс зүйд хөндлөнгөөс нөлөөлөхөөр оролдсон; */2012 оны 3-р сарын 23-ны өдрийн хорооны хуралдааны тогтоолоор нэмсэн/*
- 4.18. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 8.1.3-т заасан үйл ажиллагаа явуулсан

## **5. КОНТЕНТ НИЙЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИД ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА**

Контент нийлүүлэх үйлчилгээ эрхлэгчдэд дараах нөхцөл шаардлага тавигдана:

- 5.1. Контент нийлүүлэгчийн контент бүтээгчдэд тавих нийтлэг нөхцөл шаардлагыг үл ялгаварласан, ижил нөхцөл бололцоогоор хангах зарчмыг баримтлан тогтоож, олон нийтэд ил тод байлгана.
- 5.2. Хэрэглэгчид хүргэх контент нь энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4 дүгээр зүйлийг зөрчсөн эсэхэд хяналт тавих үүрэг хүлээх бөгөөд чанарын шаардлага хангасан контентоор үйлчилнэ.
- 5.3. Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4 дүгээр зүйлийг зөрчсөн тохиолдолд зөрчлийг гарсан даруйд нь таслан зогсоох техникийн боломж, нөхцлийг хангасан байна.
- 5.4. Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4.11-4.13-д заасан контентоор үйлчлэхдээ хэрэглэгчдэд 18-аас дээш насныханд зориулсан контентийг урьдчилан анхааруулах ба хэрэглэгчийн хүсэлтээр контентийн үйлчилгээнд тодорхой хязгаартайгаар хандалт хийх боломжийг бүрдүүлсэн байна.  
*/2015 оны хорооны хуралдааны 60 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар өөрчлөлт оруулсан/*
- 5.5. Холбоо барих мэдээлэл, хэрэглэгчийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах төлөөлөгчийн газрын хаяг болон утасны дугаар зэрэг мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгана.
- 5.6. Контентын үйлчилгээний үнийг хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдсэн байх ба үйлчилгээ эрхлэгч нь төлбөр тооцооны зарчим, төлбөр тооцоог хэрэглэгч хянах боломжийг олгоно.
- 5.7. Зохицуулах хороонд контентын үйлчилгээтэй холбоотой шаардлагатай мэдээллийг гаргаж өгнө.

## **6. ВЕБ САЙТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД ТАВИГДАХ НӨХЦӨЛ ШААРДЛАГА**

Веб сайтын үйлчилгээ эрхлэгчид дараах нөхцөл шаардлага тавигдана:

- 6.1. Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4 дүгээр зүйлийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 6.2. Хэрэглэгч контент үүсгэх боломжтой, хэрэглэгчийн сэтгэгдэл үлдээх хэсэгтэй бол дараахь зохицуулалтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ. Үүнд:
  - 6.2.1. Зохицуулах хорооноос ажиллуулж байгаа үгийн шүүлтүүр программыг заавал ашиглах.



- 6.2.2. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйлчилгээг ашиглахыг сануулсан нөхцөл шаардлагыг зөвшөөрсөн хэрэглэгчийг контент үүсгэх боломжоор хангах.
- 6.2.3. Хэрэглэгч аль нэг өөр хэрэглэгчийн үүсгэсэн контентыг хууль бус, нийтийн ёс зүйд сөрөг нөлөөтэй гэж үзвэл саналаа илэрхийлэх, саналын тооноос хамааран тухайн контентыг арилгах боломжийг бүрдүүлэх.
- 6.2.4. Хэрэглэгчийн интернет хаягийг (IP address) бүтнээр нь хэрэглэгчийн үүсгэсэн контентын дээр нийтэд харагдахуйц байрлуулах. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*
- 6.2.5. Хэрэглэгчийн үүсгэсэн контентыг 4 дүгээр бүлгийн заалтыг зөрчсөн гэж үзсэн тохиолдолд түүнийг арилгах.
- 6.2.6. Хэрэглэгч дурын нэр /username/, имэйл хаягаар логин хийж сэтгэгдэл үлдээх боломжийг бүрдүүлнэ.  
*/2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан/*
- 6.2.7. Тухайн сэтгэгдэлтэй холбоотой үүсэх логийг багадаа 6 сар хадгална. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан /*
- 6.2.8. Сайт нь сэтгэгдэлтэй холбоотой санал, хүсэлт, гомдлыг хүлээн авснаас 24 хүртэлх цагийн дотор, хойшлуулшгүй нөхцөлд нэн даруй шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан/*
- 6.2.9. Сэтгэгдэл бичигчдэд зориулсан зөвлөмж, анхааруулгыг сэтгэгдлийн талбарт харагдахуйц байршуулна. Тухайлбал: “Та сэтгэгдэл бичихдээ хууль зүйн болон ёс суртахууны хэм хэмжээг хүндэтгэнэ үү. Хэм хэмжээг зөрчсөн сэтгэгдлийг админ устгах эрхтэй” гэсэн анхааруулга байна. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан/*
- 6.2.10. Хууль зөрчсөн сэтгэгдлийг устгах боломжийг заавал бүрдүүлж ажиллана. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан /*
- 6.3. Веб сайтын үйлчилгээ эрхлэгч нь энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4.11- 4.13-д заасан контентээр үйлчлэхдээ хэрэглэгчдэд 18-аас дээш насныханд зориулсныг урьдчилан сануулж, бүртгэл хийж, бүртгэсэн нэр, нууц үгээр хандалт хийлгэнэ. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*
- 6.4. Мэдээ мэдээллийн вебсайт нь бусад веб сайт руу холбоос хийж харуулахыг дараах тохиолдолд хориглоно. Үүнд:
- Мэдээлэл нь хууль зөрчсөн, хууль бус материалыг тараан түгээх зорилготой бол
  - Зохиогчийн эрхийг зөрчсөн болон зөрчихөд хүргэсэн бол
  - Хууль зөрчсөн мэдээлэл агуулаагүй хэдий ч хэрэглэгчийг төөрөгдүүлсэн бол
  - Фреймийг зөвхөн өөрийн веб сайтыг оновчтой зохион байгуулахын тулд ашиглаж болох бөгөөд харин бусдын контентийг шууд байрлуулахыг

*/2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан/*

- 6.5. Веб сайт эзэмшигч нь “WHOIS” мэдээллийн сангийн бүртгэлд домэйн нэр эзэмшигчийн талаарх мэдээллийг үнэн зөв, дэлгэрэнгүй оруулна. Эзэмшигчийн мэдээлэл өөрчлөгдөх тухай бүрт шинэчлэх үүрэг хүлээнэ.
- 6.6. “Холбоо барих” хэсэг нь нүүр хуудсанд ил харагдахуйц байрлана.
- 6.7. Веб сайтын үйлчилгээ эрхлэгч нь хэрэглэгчийг хандах үед ямар нэгэн анхааруулга, зөвшөөрөл авалгүйгээр тухайн хэрэглэгчийг өөрийн сайтын фейсбүүк хуудас дээр автоматаар “LIKE” даруулахыг хориглоно. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан/*
- 6.8. Энэхүү нөхцөл шаардлагыг биелүүлээгүй веб сайтын үйлчилгээ эрхлэгчийн Монгол улсаас хандах хандалтыг хязгаарлана. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан /*
- 6.9. Сайтууд нь доорх мэдээллүүдийг “Холбоо барих” хэсэгт заавал байршуулах бөгөөд тухайн холбоо барих мэдээллүүд өөрчлөгдөх бүрт шинэчлэх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.
- 6.9.1. Хаяг
- 6.9.2. Э-Шуудан
- 6.9.3. Холбоо барих, сэтгэгдэлтэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах утас

## 7. ХЯНАЛТ

- 7.1. Зохицуулах хороо энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4 дүгээр зүйлд зааснаас бусад заалтуудад хамаарах хяналтыг хэрэгжүүлнэ.
- 7.2. Зохицуулах хороо хяналтыг хэрэгжүүлэхдээ дараах арга хэрэгслийг ашиглана:
- 7.2.1. Хэрэглэгч, байгууллагын өргөдөл, гомдлын дагуу шалгалт хийх.
- 7.2.2. Контент нийлүүлэх болон веб сайтын үйлчилгээ эрхлэгчээс шаардлагатай мэдээ, тайлан гаргуулах;
- 7.3. Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагын 4 дүгээр зүйлд дурдсан агуулгын хяналтыг холбогдох хуульд заасан эрх бүхий хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

## 8. ГОМДОЛ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон веб сайтын үйлчилгээ эрхлэгч нь өргөдөл, гомдол хүлээж авч, шийдвэрлэх өөрийн журамтай байх ба өргөдөл, гомдол хүлээж авах хаяг, утас зэрэг мэдээллийг ил тод мэдээлнэ. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*
- 8.2. Гомдол, маргаантай асуудлыг маргалдагч талууд шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шаардлагатай бол Зохицуулах хороонд хандаж болно.
- 8.3. Харилцаа холбооны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн дагуу Зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд гомдол, маргааныг шийдвэрлэхдээ Зохицуулах хорооноос

баталсан “Гомдол, маргааныг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам”-ыг мөрдлөг болгоно.

## 9. ХАРИУЦЛАГА

9.1. Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагыг зөрчсөн тохиолдолд Зохицуулах хороо нь зөрчлөөс хамааруулан тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан эдийн засгийн хариуцлага хүлээлгэх эсхүл холбогдох хууль тогтоомжийн дагуу дараах шаардлагатай арга хэмжээг авна:

9.1.1. Зөрчлийг арилгуулах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх.

9.1.2. Захиргааны хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх;

9.1.3. Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах;

9.1.4. Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх;

9.1.5. Тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох;

*/2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

9.2. Зохицуулах хороо нь холбогдох эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хууль, тогтоомж зөрчсөн тухай албан ёсны шийдвэр, дүгнэлтийг үндэслэн дор заасан арга хэмжээ авахыг контентын агрегатор, веб сайтын үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэнэ.

9.2.1. Энэ талаар мэдэгдсэнээс хойш 24 хүртэлх цагийн дотор, шаардлагатай гэж үзвэл нэн даруй уг зөрчлийг арилгах арга хэмжээ авч хариуг мэдэгдэх. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

9.3. Хэрэв 9.2.1-д заасан хугацаанд зөрчлийг арилгахгүй бол зөрчил арилтал контент агрегаторын үйлчилгээг зогсоох болон веб сайтын үйлчилгээ эрхлэгчийн Монгол улсаас хандах хандалтыг хязгаарлаж Зохицуулах хорооноос үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэнэ. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

9.4. Эрх бүхий байгууллагаас Монгол улсаас хандах хандалтыг хязгаарлах тухай ирүүлсэн албан ёсны мэдэгдэл, албан бичигт үндэслэн тухайн веб сайтын үйлчилгээ эрхлэгчид мэдэгдэл хүргүүлэхгүйгээр веб сайтын хандалтыг нэн даруй хязгаарлаж болно. */2014 оны хорооны хуралдааны 40 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

9.5. Гаргасан зөрчил, зөрчлийг арилгуулахаар авсан шийдвэрийг Зохицуулах хороо тухай бүр холбогдох талууд болон олон нийтэд ил тод мэдээлнэ.

9.6. Зохицуулах хороо нь контент агрегатор, веб сайтын үйлчилгээ эрхлэгч болон үйлчилгээ эрхлэгчээс авсан бизнесийн болон хэрэглэгчдийн мэдээллийг зөвхөн зохицуулалтын үйл ажиллагаанд ашиглана.

**Хорооны 2015 оны 60 тоот тогтоолын 3 дугаар хавсралт:**

Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2011 оны 42 тоот тогтоолын  
хавсралт

**КОНТЕНТ НИЙЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГА**

**(Хорооны 2015 оны 53 тоот тогтоолын 2 ба 3 дугаар хавсралт,  
2015 оны 60 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар  
нэмэлт, өөрчлөлт оруулсан)**

**1. Ерөнхий зүйл**

- 1.1. Энэхүү баримт бичгээр харилцаа холбооны сүлжээгээр тоон контентын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргагчид болон энэхүү тусгай зөвшөөрлийг эзэмшигчдэд тавигдах тусгай нөхцөл шаардлагуудыг тодорхойлно.
- 1.2. Харилцаа холбооны сүлжээгээр контентын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Харилцаа холбооны зохицуулах хорооны(цааших Зохицуулах хороо гэх) “Тоон контентын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”, “Сүлжээ байгуулах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн ерөнхий нөхцөл шаардлага” болон энэхүү тусгай нөхцөл шаардлагыг мөрдөж ажиллана.  
*(2015 оны 53 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар өөрчлөлт оруулсан)*
- 1.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын 5.2-д заасны дагуу оюуны өмчийн эрхийн зөрчилгүй контентээр үйлчлэх үүрэг хүлээнэ.  
*(2015 оны 53 тоот тогтоолын 2 дугаар хавсралт, 2015 оны 60 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар тус тус өөрчлөлт оруулсан)*
- 1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчдэд үйлчилгээ, үнийн ялгавартай бодлого барихгүй байх үүрэгтэй .

**2. Техникийн нөхцөл шаардлагууд**

- 2.1. Техник тоног төхөөрөмжүүд нь Зохицуулах хорооноос зөвшөөрөгдсөн олон улсын лаборатори, байгууллагын баталгаажуулалтын гэрчилгээтэй байна.
- 2.2. Оператор компанитай SSL сертификаттай протокол ашигласан холболт хийсэн байна.
- 2.3. “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын 4 дүгээр зүйлд заасан контентын 24 цагийн дотор таслан зогсоох техникийн боломж, нөхцөлийг хангасан байна.
- 2.4. Найдвартай ажиллагааг бүрэн хангах үүднээс найдвартай ажиллагааны төвшинг 99 хувиас дээш хангаж ажиллана.

- 2.5. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах боломжийг бүрдүүлэх үүднээс оператор компанитай тусгай (dedicated) шилэн кабелийн шугамаар холбогдох шаардлагатай бөгөөд хамгаалалт хангасан протокол ашигласан байх ёстой.
- 2.6. VPN холболт үүсэх боломж бүхий нууцлалын (Firewall) төхөөрөмжтэй байна.
- 2.7. Системийн хэт ачааллаас хамгаалах үүднээс үйлчилгээ эрхлэгч рүү хандах интерфэйсийн хувьд ачааллын хязгаарлалт тавьдаг боломжтой байх ба ачаалал даах чадварын хэмжээг баталгаажуулсан байна.
- 2.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн систем нь өөрийн гэсэн хяналтын програмтай байх ёстой бөгөөд гэмтэл гарсан үед SNMP протокол ашиглан шаардлагатай дохиоллыг үйлчилгээ эрхлэгчид мэдээлдэг байна.

### **3. Холболт**

- 3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бусад үйлчлэгчдийн сүлжээтэй харилцан холболт хийхийн өмөн урьдчилан туршилт хийж, протокол үйлдэн хувийг Зохицуулах хороонд ирүүлнэ.
- 3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь контентыг нийлүүлэгчдэд тавих журмыг боловсруулж, Зохицуулах хороогоор хянуулна. Уг нөхцөл шаардлага нь үйл ялгаварласан, ойлгомжтой, тодорхой байх шаардлагуудыг хангасан байна. Контентын агрегатор нь уг нийтлэг нөхцөл шаардлагыг тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор Зохицуулах хороонд ирүүлнэ.
- 3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээ эрхлэгчтэй харилцан холболтын тооцоо хийхэд шаардлагатай статистик, тайлан мэдээг гаргадаг системтэй байна.
- 3.4. Дотоодын контентийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор контент нийлүүлэх үйлчилгээ эрхлэгч нь Интернетийн харилцан холболтын төвд холбогдож болно.  
*(2015 оны хорооны хуралдааны 60 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар нэмсэн)*

### **4. Үйлчилгээнд тавигдах шаардлага**

- 4.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн контентын үйлчилгээ бүрийн тайлбар, ангилал, хэрэн хандаж үйлчилгээ авах, контентын үнэ, үйлчилгээний төлбөрийг үнэн зөв ойлгомжтойгоор хэрэглэгчдэд үйлчилгээ авах бүрд урьдчилан мэдээлдэг байна.
- 4.2. Төлбөр тооцооны системийн тухай болон хэрхэн төлбөр төлөх талаар тайлбарыг үнэн зөв ойлгомжтойгоор хэрэглэгчдэд мэдээлсэн байна.
- 4.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчийн мэдээллийг хадгалахдаа нууцлалын хувиргалт хийдэг байна. (encrypt)
- 4.4. Хэрэглэгчдэд үзүүлэх контентын үйлчилгээнд шаардах (content management system) контент менежмент системтэй байна. Шинээр өргөдөл гаргахдаа болон тусгай зөвшөөрөл авснаас хойш жил тутам content management system-ийн дэлгэрэнгүй тайлбар, системийн блок зургийг Зохицуулах хороонд ирүүлнэ.

- 4.5. Зохицуулах хорооноос тогтоосон үйлчилгээний чанарыг хангаж ажиллах ба тэдгээрийг хянах техникийн боломжийг бүрдүүлсэн байна.
- 4.6. Төлбөр тооцооны систем нь секундйн алхамтай болон тоо ширхгийн нарийвчлалтайгаар төлбөрийг тооцох боломжтой байна. Шинээр өргөдөл гаргахдаа болон тусгай зөвшөөрөл авснаас хойш жил тутам контентын үйлчилгээний төлбөрийн системийн бүтцийн тухай Зохицуулах хороонд ирүүлнэ.
- 4.7. Контентын үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчдийн гомдлыг шийдэх журам, CRM системтэй байна. Шинээр өргөдөл гаргахдаа болон тусгай зөвшөөрөл авсанаас хойш жил тутам гомдлыг шийдэх журам, CRM системийн тухай дэлгэрэнгүй тайлбарыг Зохицуулах хороонд ирүүлнэ.
- 4.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйлчилгээ эрхлэгчтэй Зохицуулах хорооноос гаргасан загварын дагуу SLA(Service Level Agreement) гэрээ байгуулсан байна.

----- о О о -----